

ГУРВАН ТЕЛЕВИЗИЙН ГУРВАН ЦАГ ДАВСАН ЯРИЛЦЛАГАД ХИЙСЭН ШҮҮМЖ

Э.Дагиймаа*

**МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн докторант*

Түлхүүр үгс: Телевизийн ярилцлага, улс төрийн сэтгүүл зүй, өгүүлэхүйн онол, олон ургальч үзэл, сэтгүүл зүйн чанар, контент шинжилгээ, access journalism

Оршил. Телевизийн салбарт ярилцлагын төрөл зонхилох болсон нь нийгэмд өрнөж буй үйл явдлыг шуурхай, өргөн хүрээнд хүргэх шаардлага нэмэгдсэнтэй шууд холбоотой юм. Ярилцлагын хэвлэлийн онол нь сэтгүүл зүйн үндсэн арга зүйд тулгуурлаж, мэдээлэл цуглуулах, олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх, нийгмийн харилцааг шинжлэх учиртай. Өөрөөр хэлбэл ярилцлага нь зөвхөн мэдээлэл авах биш үнэн зөв мэдээлэл түгээх, харилцааны соёл түгээх зарчмыг бас хадгалдагаар онцлог. Сүүлийн жилүүдэд телевизийн сэтгүүл зүйд улс төрийн ярилцлага, шууд нэвтрүүлэг, ток шоу, подкаст хэлбэрийн контентууд бэлтгэгдэж, үзэгч, сонсогчид хүрэх болсон. Ялангуяа төрийн өндөр албан тушаалтан болон дуулиант мэдээлэлд нэр нь холбогдсон улс төрч, урлаг соёл, нийгмийн зүтгэлтэнүүдийн ярилцлага олон нийтийн анхаарал татаж, мэдээллийн эх сурвалж болж байна. Энэхүү телевизийн салбарт зонхилох болсон шалтгаан нь

1. Өрнөж байгаа үйл явдал
2. Шуурхай мэдээллийг хүргэх
3. Олон нийтийн анхаарлыг татсан гол дүрээс тодруулга авах нь сэтгүүлчдийн ур чадвар оролдлого төдийгүй олон нийтийн хүлээлттэй шууд холбоотой юм.

Тиймээс энэхүү судалгаанд Монголын Үндэсний Олон нийтийн телевизээр цацагдсан Монгол Улсын Ерөнхий сайд Г. Занданшатар болон ОХУ –ын төв телевизээр гарсан тус улсын Ерөнхийлөгч В. В. Путин, арилжааны өргөн нэвтрүүлгийн суваг болох NTV цацагдсан МУ –ын 31.32 Ерөнхий сайдаар ажиллаж байсан Л. Оюун-Эрдэнийн улс төрийн ярилцлагыг авч үзэж, тэдгээрийн агуулга, хэлбэр, сэтгүүл зүйн чанарыг харьцуулан шинжиллээ.

Дээрх гурван ярилцлага нь 180 минутаас дээш хугацаанд үргэлжилсэн нь телевизийн эфирийн үнэт цагаа зарцуулсан контент болохыг харуулж байна. Ийм урт хугацааны ярилцлага нь олон нийтэд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлогыг тайлбарлах, итгэл үнэмшил бий болгох чухал үүрэгтэй.

Тиймээс гурван телевизийн ярилцлагыг агуулга+ хэлбэр хосолмол шинжилгээний үүднээс

Агуулгын талаас: Гурван ярилцлагад зочдын үзэл бодол ямар хүрээнд туссан болон олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн эсэх, мэдээллийн бодит байдал, тэнцвэртэй байдал.

Хэлбэрийн талаас: телевизийн өгүүлэмж, бүтцийн шийдэл, асуулт-хариултын ур чадвар, үзэгчийн оролцоог хэрхэн дэмжсэн гэх мэт үзүүлэлтүүдээр харьцуулан шүүмж бичлээ.

Үндсэн хэсэг

Энэхүү судалгаанд агуулгын шинжилгээ болон харьцуулсан судалгааны аргыг ашигласан. Ярилцлагуудыг :

- агуулгын чанар
- хэлбэр, бүтэц
- оролцогчдын олон талт байдал
- асуулт-хариултын логик
- баримт нотолгоо гэх мэт шалгуураар үнэлэв

Онолын үндэс болгон өгүүлэхүйн онол, сэтгүүл зүйн чанарын онол, access journalism болон constructive journalism-ийн хандлагыг ашиглав

Сеймур Чатман (Chatman, 1978) өгүүлэхүйг “түүх”, “өгүүлэх хэлбэр”, “дүрслэл” гэсэн гурван бүрэлдэхүүнтэй гэж тодорхойлсон бөгөөд мэдээлэл нь логик дараалалтай, ойлгомжтой байх ёстойг онцолсон.

Мөн McQuail (2010)-ийн тодорхойлсноор сэтгүүл зүй нь мэдээлэхээс гадна нийгмийн хяналт хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнтэй уялдан улс төрийн ярилцлага нь эрх мэдэлтнээс хариуцлага нэхэх чухал механизм юм.

Гэвч access journalism буюу эх сурвалжид ойр байх зорилгоор шүүмжлэл багатай ярилцлага хийх хандлага нь сэтгүүл зүйн чанарыг бууруулдаг.

Харин constructive journalism нь асуудал, шалтгаан, шийдэл, хариуцлагыг хамтад нь авч үзэхийг шаарддаг (McIntyre, 2019).

Энэ бүхэнд тулгуурлан гурван телевизийн ярилцлагыг сонгож, шүүмж бичлээ. Тухайн нэвтрүүлэгт оролцогчдын хувьд үнэхээр нийгэм олон нийтийн анхаарлыг татсан, хүлээлт бүхий зочид юм. Тогтмол хэвлэлээр бол “Хадаас буюу Ховор зочин”, телевиз талдаа “Сенсааци буюу Дуулиан” тарьсан эрхэмийг зочны хойморт суулгаж чадсан учраас ийнхүү онцлож байна.

Энэхүү нэвтрүүлгийн сэтгүүлч, хөтлөгч нь урьсан зочинтой иргэдийн хүлээлт бүхий асуултад хариулт авч чадсан уу, улс орны эдийн засаг хөгжил, дэлхий нийтэд хариулт өгөх хэмжээний агуулга гаргасан уу гэдгийг дараахь байдлаар судаллаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Г. Занданшатар болон ОХУ –ын Ерөнхийлөгч В. В. Путин нарын ярилцлагыг төрийн мэдлийн төв телевиз хийсэн учраас тайз дэлгэц, болон оролцогч, асуулт бэлтгэх хүрээ, хамрах цар сайн байсныг дурьдах нь зүйтэй.

Энэхүү хоёр ярилцлагыг үзэгчдэд түгээхдээ

1. Нэвтрүүлгийн эфирт зарлагдсан цаг хугацааг тодорхой зарласан
2. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор урьдчилсан цахимаар болон утсаар асуулт авч, мөн шууд нэвтрүүлэгт иргэд, төр, төрийн бус байгууллага, бизнесийн төлөөлөлийг хамруулсан
3. Бүс нутаг бүрийн онцлогийг харуулсан, тулгамдсан асуудлыг тодорхойлсон асуулт асууж, мэдээлэл өгөхийг зорьсон
4. Сэтгүүлч, хөтлөгч мэргэжлийн түвшинд сул үг багатай, асуултыг шууд тавих замаар нэвтрүүлэг хөтөлсөн байна.
5. Нэвтрүүлгийг сонирхолтой болгох зочин тодорхой хугацаанд, товч тодорхой асуултанд хариулах шийдлийг сонгосон байна.

Тухайлбал ОХУ –ын Ерөнхийлөгч В. В. Путины жил бүр хийдэг шууд ярилцлага нэвтрүүлэг нь “Оны онцлох хэвлэлийн хурал” нэртэй телевиз, радио станц, цахимаар цацагддаг уламжлалтай.

Сэтгүүлч, оролцогчдын асуултад хариулдаг энэхүү шууд нэвтрүүлэгт анх 20 гаруй сэтгүүлч асуулт асууж байсан бол 80 гаруй сэтгүүлчийн асуултад болтлоо өргөжжээ. Цаашлаад гадны 18 байгууллагын төлөөлөл ч шууд нэвтрүүлгийн үед асуулт асууж, хариулт авсан сонирхолтой статистик гарчээ.

Оросын 1 –р суваг, Россия суваг, Оросын радио, Маяк радио станцаар шууд нэвтрүүлэг цацагддаг.

Үүнээс хархад хэвлэлийн хурлын хэлбэр агуулгатай энэхүү ярилцлагад

оролцох хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл 10 дахин өссөн дүнтэй байна.

Цар тахлын хүнд үед энэ шууд нэвтрүүлэгт оролцогчдын хувьд хязгаарлалт хийсэн ч тухайн жил 774 хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд дамжуулсан түүхтэй.

ОХУ –ын Ерөнхийлөгч В. В. Путины ярилцлагын агуулга нь улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, гэмт хэрэг, эрүүл мэнд, дэд бүтэц, олон улсын харилцаа, боловсрол, соёл урлаг, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамж, байгаль экологи, хувийн гэхчлэн бүхий л салбарыг хамардаг.

Сүүлийн 2 жилийн ярилцлагын гол агуулгад дүн шинжилгээ хийхэд Украин- Оросын дайн, эдийн засгийн боломж, хориг саадыг гэтлэн давах орос орны чадавхи болон бүтээн байгуулалт, үйлдвэржилтийн бодлогыг түлхүү ярьжээ.

Өөрөөр хэлбэл ОХУ –ын Ерөнхийлөгчийн ярилцлага нь зөвхөн дотоодын асуудлаас илүүтэй олон улсын, дэлхийн хэмжээний асуудлыг хөндөж, ОХУ –ын байр суурийг тодорхойлж өгсөн байна.

Хамгийн анхны ярилцлага 1 цаг 45 минут болж байсан бол өнгөрсөн оны ярилцлага 4 цаг гаруй хугацаанд үргэлжилсэн.

Сэтгүүлчдийн асуултын 50 –аас дээш хувь нь энх тайван, дайны гал зогсоох, дэлхийн удирдагчдын уулзалтын талаар байлаа

Жил бүр уламжлал болгон 2001 оноос хойш хийж байгаа ОХУ-ын төв телевизийн ОХУ –ын Ерөнхийлөгчтэй хийсэн ярилцлагын гол асуултыг хэвлэл мэдээллийн төлөөлөл тавьж ирсэн онцлогтой. Тиймээс ч ярилцлагын хэлбэрээ “ Хэвлэлийн бага хурал” гэсэн хийц, загварыг сонгосон байна.

Тэгвэл 2026 оны 1 сарын 17-ны өдөр МҮОНТВ- ээр Монгол Улсын Ерөнхий сайд Г. Занданшатар “ Ерөнхий сайдаас асууя” шууд ярилцлагад орсон. ОХУ –ын Ерөнхийлөгч В. В. Путины ярилцлага ч шууд гэдгээрээ харьцуулах боломжтой гэдгийг тодотгоё.

Дээрх хоёр ярилцлагын ижил төстэй зүйл нь :

Шууд ярилцлага болох өдрөө товлон, эрт зар тарааж, иргэд, үзэгч сонсогчыг ил тод мэдээллээр хангасан

Олон сувгаар, олон асуултад хариулах боломжоо нээсэн

Ганц сэтгүүлч, хөтлөгчид хөтлөгдөөгүй. Хэлбэр хийцийн хувьд хэвлэл мэдээллийн олон ажилтан хамруулсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Г. Занданшатарын шууд ярилцлагын нэвтрүүлэгт 300 гаруй иргэн асуулт илгээж, E Mongolia цахимаар 10 мянган

иргэн санал ирүүлжээ. Орон нутгийн 12 аймаг, 5 улс орноос иргэдийн төлөөлөл биечлэн оролцож, асуулт асуусан. МҮОНТВ орон нутаг дахь 20 гаруй тусгай сурвалжлагч, Улаанбаатар хотод 4 явуулын станц ажилласан байна.

Цар хүрээний хувьд ярилцлага нь иргэд, төр, бизнес, орон нутгийн төлөөлөлийг хангасан төдийгүй сэтгүүлчдийг ч өргөн хүрээтэй оролцуулжээ

Ярилцлагын агуулгад хийсэн дүн шинжилгээгээр эрүүл мэнд, цалин тэтгэвэр, нийгмийн даатгалтай холбоотой асуулт 35 хувь, уул уурхай, эдийн засагтай холбоотой асуудал 20 гаруй хувь, албан тушаал, улс төрийн үйл явцтай холбоотой асуулт 9 хувь, боловсролын салбар 6 хувь, авлига хээл хахууль албан тушаалын хэрэгтэй холбоотой асуудал 10 гаруй хувь эзэлсэн байна.

Хоёр улсын төв телевизээр бэлтгэгдэн цацагдсан дээрх хоёр ярилцлага нь сэтгүүл зүй талаасаа олон ургальч үзлийг багтаасан, хөтлөгч, оролцогч, зочны оролцоог нэмэгдүүлсэн, салбар бүрийн асуудлыг хөндсөн төдийгүй хамгийн гол нь тоо нь судалгаатай товч мэдээллийг тодорхой өгч чадсанаар давуу байлаа.

Хэт дуулиан, шуугианд тааруулсан шуурхай ярилцлагаас зайлсхийж, өргөн цар хүрээгээр, олон нийтийн санаа бодолд мэдээлэл, мэдлэг өгөх ярилцлага болжээ.

Тэгвэл гурав дахь ярилцлага нь NTV телевизээр гарсан “Лхавгын тойм” нэвтрүүлэг юм. Монгол Улсын 32,33 дахь Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнийн 2026 оны 3 сарын 11 өдөр оролцсон 6 цаг буюу 360 минутын ярилцлагыг авч үзэе.

Энэхүү ярилцлага нь дээрх хоёр ярилцлагатай харьцуулахад олон талын оролцоог хангаагүй. Зөвхөн хөтлөгч сэтгүүлч, зочин гэсэн ярилцлага хэлбэрээр явагдсан. Ингэснээр хамрах цар хүрээний хувьд хумигдмал байсан ч үзэгч, иргэдийн хувьд “Хүлээлтээр дүүрэн зочин” байсныг дурьдах нь зүйтэй.

Харин ярилцлага нь “Хүлээлтээс доогуур” боллоо гэсэн дүгнэлтийг үзэгчид өгчээ. Шалтгаан нь :

Зочин асуудлыг тойруу замаар их нуруу тайлбарласан. Асуултандаа тодорхой, товч хариулж чадаагүй

Баримт, материал үзүүлээгүй. Нотлох баримт хангалтгүй байсан

Удаан хүлээсэн ярилцлага гэсэн тодотгол байсан ч иргэдийн эргэлзээг тайлах асуудлуудад тайлбар хэлж чадаагүйд оршиж байлаа

6 цагийн ярилцлагад мэргэжлийн судалгааны байгууллага дүгнэлт хийхэд МУ –ын Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүн атлаа “ Засгийн газар” гэдэг үг нэг ч удаа хэлээгүй. “ Засаг” гэдэг үгийг 90 удаа давтсан.

Хууль зүй дотоод хэргийн сайд Б. Энхбаярыг 52 удаа, УИХ –ын дарга Амарбаясгаланг 50 удаа нэрийн дурьджээ

Агуулгын хувьд өөрийн байр сууриа идвэхтэй өмөөрч, Эрдэнэтийн 49 хувь, Хөгжлийн банкны зээл, Боловсролын зээлийн сангийн талаар хөндөж, МАН –ын дотоод зөрчил болоод төрийн институц хоорондын ажлын давхцал, маргаан, үл ойлголцолыг хөнджээ.

Иргэдийн хамгийн их анхаарал татсан “ Орлогоо нотлох” асуудалд тэрээр маш хайнга хандсан байгааг энэхүү ярилцлага харууллаа.

Ардчилал нь эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас үүдэн ганхаж байгааг сануулж, Ерөнхийлөгчийн институцэд шүүмжлэлтэй хандаж байгааг ярьлаа.

Ярилцлага нь хэт их нуршуу атлаа тайлбар нь оновчгүй байсан нь үзэгчдийг уйдааж, сонирхол татах хэлбэр нь буурч, эхний хэсэгт цахим болон ТВ үзэлт өндөр байгаад аажимдаа буурсан үзүүлэлтээс харагдаж байна.

Гурван телевизийн ярилцлагаас дүгнэлт, дүн шинжилгээ хийж үзвэл:

А. Телевизийн ярилцлага хийхдээ олон жилийн дадлага туршлагатай сэтгүүлч, хөтлөгч сонгох нь чухал гэдгийг харуулсан

Б. Олон ургальч үзэл, иргэд, үзэгч сонсогчийн оролцоог нэмэгдүүлж байж ярилцлага сонирхолтой, ритмтэй, үзэгч уйдаахгүй байх зарчмаа хадгалах ёстой

В. Зочны биеийн хэлэмж, баримт материал, нотолгоо, эдийн засгийн тоо баримт чухал байгааг харуулсан.

Г. Үзэгчдэд итгэл үнэмшил төрүүлэх, нуршихгүй байх, нэг санааг олон давтахгүй байх ёстойг харьцуулалтаар харууллаа

Нөгөө талаар гурван ярилцлага гурвуулаа телевизийн сувгаараа үзэгч өндөртэй, цахим хандалт багатай, бодит хаягаас асуудалд хандсан иргэд цөөн, тролл ихтэй байсныг судалгааны байгууллага гаргажээ

Тэгвэл дээрх гурван ярилцлагаас харахад МҮОНТВ болон ОХУ –ын телевизийн ярилцлага нь:

А. Урьдчилан асуулт авсан

Б. Олон сувгаар дамжуулсан

В. Бүс нутгийн асуудал хамруулсан

Г. Тоон мэдээлэл ашигласан нь олон ургальч үзэл болон сэтгүүл зүйн

чанарын шаардлагыг хангасан байна.

Харин NTV “Лхавгын тойм” ярилцлага нь

1. Нэг эх сурвалжтай
2. Баримт дутмаг
3. Нуршуу
4. Асуулт тодорхой бус, логик дараалал муутай байсан нь сэтгүүл зүйн дараахь онолыг гажуудуулсан байна.

Өгүүлэхүйн онолоор логик бүтэц алдагдсан төдийгүй сэтгүүл зүйн чанарын хувьд баримт, нотолгоо, тэнцвэртэй байдал дутагдсан нь харагддаг. Мөн сэтгүүлч, хөтлөгч нь урьсан зочноо хэт хамгаалсан хэлбэртэй буюу Access journalism-тай болсон нь нотлогдож байна. Хамгийн чухал үзүүлэлт бол энэхүү ярилцлагын дараах шийдэл, хариуцлага, хүлээгдсэн үр дүн байгаагүй нь сэтгүүл зүйн хувьд дутмаг ажил болсон гэж үзэх үндэслэлтэй.

Олон улсын жишээтэй харьцуулбал энэ ялгаа илүү тод харагдана.

BBC-ийн Prince Andrew ярилцлага нь баримтад тулгуурласан, хариуцлага нэхсэн асуулттай байсан бөгөөд бодит улс төрийн үр дагаварт хүргэсэн.

CBS-ийн “60 Minutes” нэвтрүүлгийн ярилцлага нь бодлогын түвшинд, олон өнцгөөс, баримтад тулгуурлан хийгдсэн байдаг.

Эдгээр жишээнээс харахад сайн ярилцлага нь:

- баримт
- шүүмжлэл
- логик бүтэц дээр суурилж ирсэн тодорхой байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаа, харьцуулалтаас харахад телевизийн ярилцлага нь олон хэлбэрээр хөгжиж байгаа ч чанар, хэлбэр, агуулга, үр дүн муутай болж байгааг нийгэмд дуулиан тарьсан гурван телевизийн гурван том хэмжээний ярилцлагад хийсэн судалгаа харуулж байна.

Ярилцлага нь хугацааны хувьд урт байснаар чанартай болж, нийгмийн хүлээлтэд хариулт өгдөггүй. Харин ч нуршуу, уйтгартай, үзэгчийг залхаах, зочныг төвлөрөл саарах, асуудлын мөн чанар нь ч алдагдахад хүргэдэг. Нэг асуудлыг олон давтах, хариулт давхцах, баримт нотолгоо замхардаг гэдгийг ажиглаж болно.

Үүнд:

1. Урт ярилцлага заавал чанартай байдаггүй
2. Ярилцлагын чанар нь агуулга, бүтэц, асуултын чанараас хамаарна

3. Нэг талын ярилцлага нь үзэгчийн итгэлийг бууруулдаг
4. Орчин үеийн ярилцлага нь хариуцлага нэхэх үүрэгтэй байх ёстой. Телевизийн ярилцлагын төрөл хэлбэр хийцийн хувьд сайжирч байгаа ч агуулга чанарын хувьд тааруухан байна. Энэ нь олон нийтийн анхаарлыг татсан дуулиант ярилцлагуудад хийсэн судалгаанаас харагдаж байна. Ярилцлага хийхдээ судлах, шинжлэх, асуудлаа логик дараалалтай бэлтгэх, баримт нотолгоо харуулах, үзэгчдийн итгэл үнэмшлийг төрүүлэх, зочноо хүндэтгэх, хариуцлага, шийдлийг олдог хэлбэр, агуулга руу хандуулах нь чухал юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Chatman, S. (1978). *Story and discourse: Narrative structure in fiction and film*. Cornell University Press.

McQuail, D. (2010). *McQuail's mass communication theory* (6th ed.). Sage Publications.

McIntyre, K. (2019). *Constructive journalism: An introduction*. Routledge.

Summary

This study evaluates the content, structural frameworks, and journalistic integrity of three high-profile political television interviews broadcast in Mongolia and Russia. Specifically, the research looks at MNB's live Q&A with Prime Minister G. Zandanshatar, the Russian Central TV annual press-conference-style feature with President V. Putin, and NTV Mongolia's "Lkhagva's Review" featuring former Prime Minister L. Oyun-Erdene.

While all three broadcasts exceeded 180 minutes-representing a massive commitment of airtime-their actual value to the public varied significantly. This analysis evaluates the cases by considering the viewpoints of the guests, the accuracy of the information, and the presence of different viewpoints. In addition, the paper analyzes the technical aspects of each program, focusing on the logical flow of the stories, the interview techniques used by the moderators, and their adherence to professional ethical standards.

The findings reveal a distinct gap in quality. Both the MNB and Russian Central TV broadcasts demonstrated a commitment to pluralism and constructive journalism, supported by structured participation and evidence-based discourse. In contrast, the NTV Mongolia interview, despite its unprecedented six-hour duration, suffered from a lack of diverse voices and a tendency toward repetitive, unsupported claims. Ultimately, this points to the growing risk of access journalism, where professional rigor is sacrificed for elite proximity. The study concludes that while the long-form interview remains a cornerstone of political

accountability, its success depends on a foundation of logical inquiry and professional responsibility.

Keywords: Television interviews, political journalism, narrative theory, pluralism, journalistic quality, content analysis, access journalism.